



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 4/96

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг
сайжруулах төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.2, 11.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Иргэдийн оролцоо сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилтот жил", Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлж, ил тод байдал, оролцоог нэмэгдүүлэх (Масам 2 дахь үе шат) төслийн хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх ажлыг Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө аргачлалаар иргэдийг оролцуулан зохион байгуулахыг Эр зоригийн хүч төрийн бус байгууллагад үүрэг болгосугай.

2.Иргэд Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэх, тусламж, үйлчилгээ авахад тулгамдаж буй хүндрэлтэй асуудлуудыг илрүүлэн эрэмбэлж, сайжруулах төлөвлөгөө боловсруулан хавсралтаар баталсугай.

3.Төлөвлөгөөнд хяналт тавьж, иргэдийг холбогдох мэдээ, мэдээллээр тухай бүр хангаж ажиллахыг Эр зоригийн хүч төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн дарга (А.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг дүүрэгт Масам 2 төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн ахлагч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

1123000282

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
 2023 оны 11-р дүгээр сарын 18-ны өдрийн
 11/46 дугаар захирамжийн хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ”-ӨӨР ИРГЭД ҮЙЛЧЛҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ
 ХҮНДРЭЛТЭЙ АСУУДЛУУДЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сонгон авсан асуудлууд	Хэрэгжилтийг сайжруулахад юу хийх вэ	Хариуцах эзэн	Хугацаа	Хяналт
Нэг. Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын харилцаа хандлага, сахилга, ёс зүй, хариуцлагыг сайжруулах чиглэлээр:					
1	1.1. Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах;	1.1.1 Өөрийгөө хянах болон иргэдэд анхан шатны зөвлөгөө өгч тайвшруулах чиглэлээр “Сэтгэл зүйн” сургалт зохион байгуулна	Сэтгэл зүйч С.Пүрэвдорж ЭМТ-ийн дарга Х.Ганбат	2,3-р улиралд	“Эр зоригийн хүч” ТББ
		1.1.2 Эрүүл мэндийн төв нь эмч, сувилагч, ажилтан албан хаагчдад “Харилцаа хандлага, ёс зүй, хариуцлага”-ын чиглэлээр сургалт зохион байгуулна.	ЭМТ-ийн дарга Х.Ганбат	2,3-р улиралд	“Эр зоригийн хүч” ТББ, Иргэдийн бүлэг
Хоёр. Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийг нарийн мэргэжлийн эмчтэй болгох					
(эмэгтэйчүүд, амны хөндийн эрүүл ахуйн эмч, чих хамар хоолой), нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:					
2	2.1. Эрүүл мэндийн төвийг нарийн эмчтэй болгох;	2.1.1 Одоо гэрээтэй ажиллаж байгаа “Эмальдент” шүдний эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж, 7 хоногийн 3 өдөр тогтмол ажиллуулна.	ЭМТ-ийн дарга Х.Ганбат	2-р улиралд	“Эр зоригийн хүч” ТББ, Иргэдийн бүлэг
		2.1.2 Шинээр ирж ажиллах эмэгтэйчүүдийн эмчийг амьдрах орон сууцаар хангана.	Засаг даргын орлогч Б.Болормаа	Жилдээ	“Эр зоригийн хүч” ТББ, Иргэдийн бүлэг

				бүлэг	
				"Эр зоригийн хүч" ТББ, Иргэдийн бүлэг	
	2.1.3 Эмэгтэйчүүдийн их эмч урьж, тогтвортой ажиллах боломжоор хангана.	ЭМТ-ийн дарга Х.Ганбат	Жилдээ	"Эр зоригийн хүч" ТББ, Иргэдийн бүлэг	
Гурав. Багахангай дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр:					
3	3.1 Эмч нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах:	3.1.1 Эрүүл мэндийн төвийн эмч нарыг Улсын Клиникийн 2-р эмнэлэгт туршлага судлах ажил зохион байгуулна.	НХХ-ийн дарга Б.Цогжавхлан ЭМТ-ийн дарга Х.Ганбат	2-р улиралд	"Эр зоригийн хүч" ТББ, Иргэдийн бүлэг
		3.1.2 Эрүүл мэндийн төвийн залуу эмч нарт ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	Засаг даргын орлогч Б.Болормаа ЭМТ-ийн дарга Х.Ганбат	5-8 дугаар сард	"Эр зоригийн хүч" ТББ, Иргэдийн бүлэг

Эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний талаар 275 иргэнээс авсан судалгаа, 6 удаа 120 хүн оролцсон фокус бүлгийн уулзалтаар гарсан саналуудаас эрэмбэлж сонгож авав.